



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2017 оны 04 сарын 14-ны
өдрийн 3718 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/145

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам"-ыг нэгдүгээр, "Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дэвтэр"-ийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг энэхүү батлагдсан журмын дагуу хийж гүйцэтгэхийг дүүргийн Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 212 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Бүртгэлийн дугаар 67

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2017 оны 04 сарын 14-ний өдөр



Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 14-ны өдрийн
А. дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

**ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН
АЖИЛТНЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмын зорилго худалдаа, үйлчилгээний байгууллагад ажиллаж байгаа болон шинээр ажилд орох ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд /цаашид "урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ" гэх/ хамруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг нийслэлд дүүргийн Эрүүл мэндийн төв, орон нутагт нэгдсэн эмнэлэг, нян судлалын лаборатори бүхий сумын эрүүл мэндийн төвүүдэд хийж гүйцэтгэх ба тухайн эрүүл мэндийн байгууллагад мөрдөж байгаа үйлчилгээний төлбөрийг мөрдөнө.

**Хоёр. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний төрөл,
хамрах хүрээ, хугацаа**

2.1. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хүснэгт 1-ийн дагуу дараахь ажил, үйлчилгээ эрхлэгч этгээд хамрагдана.


Хүснэгт 1

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ

№	Ажил, үйлчилгээ эрхлэгч этгээд	Үзлэг	Шинжилгээ	Хугацаа
1	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтан, ажиллагсад;	Сүрьеэ	Флюорографийн зураг (рентген зураг харалт)	Жилд 1 удаа
Арьсны халдварт өвчнүүд		-Хамар залгиурын арчдас -Нян тээгч илрүүлэх -Цагаан хорхой илрүүлэх	6 сар тутамд	

9097443 УХА0578 1116126516

2	Ус хангагч байгууллагын ус түгээгч, усан сан ариутгагч, усны машины жолооч	-Сүрьеэ -Арьсны халдварт өвчнүүд	-Нян тээгч илрүүлэх -Цагаан хорхой илрүүлэх - Флюорографийн зураг (рентген зураг харалт)	6 сар тутамд
3	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш болон хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч	- Сүрьеэ -Арьсны халдварт өвчнүүд	-Флюорографийн зураг (рентген зураг харалт) -Нян тээгч илрүүлэх -Цагаан хорхой илрүүлэх	Хичээлийн жил эхлэхээс өмнө 30 хоногийн дотор
4	Хүүхдийн зуслангийн багш, туслах багш	Сүрьеэ	-Флюорографийн зураг (рентген зураг харалт)	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө 30 хоногийн дотор
5	Хүүхдийн асрамж, халамжийн газрын багш, туслах багш	Сүрьеэ	-Флюорографийн зураг (рентген зураг харалт)	Жилд 1 удаа
6	Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн багш, дотуур байрны болон өдөр өнжүүлэх бүлгийн багш	Сүрьеэ	-Флюорографийн зураг (рентген зураг харалт)	Хичээлийн жил эхлэхээс өмнө 30 хоногийн дотор
7	Үсчин, гоо сайханч	-Сүрьеэ -Арьсны халдварт өвчнүүд	-Флюорографийн зураг (рентген зураг харалт)	Жилд 1 удаа
8	Усан бассейны багш, дасгалжуулагч, аврагч	-Сүрьеэ -Арьсны халдварт өвчнүүд	-Нян тээгч илрүүлэх -Цагаан хорхой илрүүлэх	Жилд 1 удаа
9	Зочид буудлын үйлчлэгч, сауны газрын иллэгийн ажилтан	-Сүрьеэ -Арьсны халдварт өвчнүүд	Цагаан хорхой илрүүлэх	Жилд 1 удаа
10	Эмийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанд оролцдог ажилтан	Сүрьеэ	-Флюорографийн зураг (рентген зураг харалт)	Жилд
		Арьсны халдварт өвчнүүд	-Хамар залгиурын арчдас -Нян тээгч илрүүлэх -Цагаан хорхой	6 сар тутамд



			илрүүлэх	
11	Эмийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанд оролцдог бусад эм хангамжийн байгууллагын эм, хэрэгсэлтэй харьцаж ажиллагсад	Сүрьеэ	-Флюорографийн зураг (рентген зураг харалт) -Нян тээгч илрүүлэх	Жилд удаа 1
12	Галт тэрэг, нисэх онгоцны үйлчлэгч	Сүрьеэ	Флюорографийн зураг (рентген зураг харалт)	Жилд удаа 1
		Арьсны халдварт өвчнүүд	-Хамар залгиурын арчдас -Нян тээгч илрүүлэх -Цагаан хорхой илрүүлэх	6 сар тутамд

Гурав. Ажилтанд тавигдах шаардлага

3.1.Халдварт өвчнөөр өвчилсөн буюу өвчтөнтэй хавьтал болсон тохиолдолд тухай бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдана.

3.2.Ажилтан урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дэвтэрт бичигдсэн санамж зөвлөмжтэй танилцан гарын үсэг зурж, санамжийг мөрдөж ажиллана.

Дөрөв. Ажил олгогчид тавигдах шаардлага

4.1.Ажилтныг журмын 2.1-д заасан хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ хийж урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулна.

4.2.Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн “ээрэг” гарсан ажилтнуудыг эмчилж, эрүүлжүүлэх, хөдөлмөр зохицуулалт хийх ажлыг Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

4.3.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байдал, баталгаажуулалтад хяналт тавьж ажиллана.

Тав. Эрүүл мэндийн байгууллагад тавигдах шаардлага

5.1.Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг холбогдох стандарт арга, аргачлалын дагуу үнэн зөв, бүрэн хийнэ.

5.2.Үзлэг, шинжилгээний үр дүнг эмч болон эмнэлгийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.



5.3.Эрх бүхий албан тушаалтныг тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тушаалаар томилж, гарын үсгийн тайлал болон тэмдэгийн загварыг баталгаажуулсан байна.

5.4.Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн “ээрэг” гарсан ажилтныг эмчилж, эрүүлжүүлэх арга хэмжээг авна.

5.5.Эрүүл мэндийн дэвтрийг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, ашиглана.

----oOo----



Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 14-ныгөдрийн
№ 1145 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

Б.Нүүр хуудас

А.Гадна тал

.....
/Эмнэлгийн нэр/

Урьдчилан сэргийлэх үзлэг,
шинжилгээний дэвтэр

ЗУРАГ

Дугаар.....

Байгууллагын нэр

Овог.....

Нэр.....

Эрхлэх ажил

Ажилд орсон он, сар, өдөр.....

Дэвтэр олгосон он, сар, өдөр.....

/Биеийн зураг, тамга тэмдэггүй бол хүчингүй/

Санамж

1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын 2.1-д заасны дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдана.
2. Халдварт өвчнөөр өвчилсөн буюу өвчтөнтэй хавьтал болсон тохиолдолд тухай бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдана.
3. Байгууллагын дотоод хяналт хариуцсан ажилтан болон бусад хяналт тавих эрх бүхий этгээдэд дэвтрийг шалгуулна.
4. Дэвтрийг хуурамчаар үйлдэх, засварлах, бусдад шилжүүлэхийг хориглоно.
5. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний бүрдэл дутуу, лабораторийн шинжилгээний дугааргүй, эмч, албан тушаалтны гарын үсэг, тэмдэггүй, бичигдсэн зүйл засвартай, зөвшөөрөгдсөнөөс бусад эмнэлэгт үзлэг, шинжилгээ хийлгэсэн бол хүчингүйд тооцно.

Танилцсан: /
гарын үсэг нэр

Он.....

Сүрьеэ:/Флюорограф (рентген)-ийн дугаар/

.....
/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Арьсны халдварт өвчнүүд:/үзлэгийн дугаар/

.....
/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Нян тээгч: /шинжилгээний дугаар/.....

.....
/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Хамар залгиурын арчдас: /шинжилгээний дугаар/

.....
/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Цагаан хорхой: /шинжилгээний дугаар/.....

.....
/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Баталгаажуулсан: